

МОНГОЛЫН ХИЧЭЭЛИЙН СУДАЛГААНЫ НИЙГЭМЛЭГ ҮҮСЭН БАЙГУУЛАГДСАНЫ 5 ЖИЛИЙН ОЙ

Монголын Хичээлийн Судалгааны Нийгэмлэг (МХСН) үүсэн байгуулагдсаны 5 жилийн ойн арга хэмжээ болон “ХҮҮХДИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖСЭН БАГШЛАХ АРГА ЗҮЙ-2018” сэдэвт уламжлалт онол практикийн VI бага хурал 2018 оны 11 дугаар сарын 16, 17-ны өдөр амжилттай зохион байгуулагдлаа.

МХСН үүсэн байгуулагдсаны 5 жилийн ой ойд зориулсан хот, хөдөөгийн ЕБ-ийн сургууль, цэцэрлэг, багш бэлтгэдэг их дээд сургуулиуд хичээлийн судалгааны талаарх практик туршлагаа хуваалцан үзэсгэлэн гаргасан нь энэ жилийн шинэлэг арга хэмжээ байлаа. Үзэсгэлэнд Орхон аймгийн IV цэцэрлэг, Өвөрхангай аймгийн 1-р сургууль, Завхан аймгийн Чандмана-Эрдэнэ, Хөвсгөл аймгийн Дэлгэрмөрөн ЦС, Сэлэнгэ аймгийн Түшиг, IV сургууль, Дорнод хэрлэн-12, нийслэлийн “Шинэ эхлэл”, 45, 28, МУИС-ийн хими дидактикийн, физик дидактикийн хамтлаг, МУБИС-ийн судлаачид оролцлоо.



Үзэсгэлэнг ХСН-ийн удирдах зөвлөлийн дарга Б.Хишигбаяр нээж үг хэллээ.



Хурлын үеэр 15 байгууллага, хичээлийн судалгааны мэргэжлийн багууд үзэсгэлэн гаргаж, арга зүй туршлагаа хуваалцав.

Хурлын эхэнд 9.00-11.00 цагт МХСН-ийн үүсэн байгуулагдсаны 5 жилийн ойн ёслол хүндэтгэлийн арга хэмжээ явагдлаа. Ёслол хүндэтгэлийн үйл ажиллагааг Боловсрол, соёл, шинжлэх ухаан спортын яамны Ерөнхий боловсролын бодлогын газрын дарга Т.Ням-Осор нээж баяр хүргэж үг хэллээ. Тэрээр, “Хичээл заахаас өмнө хүүхдээ, агуулгаа, арга зүйгээ судалж, бэлтгэснээр багш нь судлаач багш, сургууль нь сурагчдын хөгжлийг дэмжсэн, сургалт нь

суралцахуйг дэмжсэн болох юм. БСШУСЯ нь хүүхдийн хөгжлийг дэмжсэн хичээлийн судалгааг цаашид тогтмол, тогтвортой хэрэгжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэхэд онцгой анхаарна” гэж хэлсэн үгэндээ онцлоод хурлыг зохион байгуулагч байгууллага болон оролцогчдод талархал илэрхийллээ.



Тэрээр, “Хичээл заахаас өмнө хүүхдээ, агуулгаа, арга зүйгээ судалж, бэлтгэснээр багш нь судлаач багш, сургууль нь сурагчдын хөгжлийг дэмжсэн, сургалт нь суралцахуйг дэмжсэн болох юм. БСШУСЯ нь хүүхдийн хөгжлийг дэмжсэн хичээлийн судалгааг цаашид тогтмол, тогтвортой хэрэгжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэхэд онцгой анхаарна” гэж хэлсэн үгэндээ онцлоод хурлыг зохион байгуулагч байгууллага болон оролцогчдод талархал илэрхийллээ.

Мөн Боловсролын хүрээлэнгийн захирал П.Лхагвасүрэн, Багшийн Мэргэжил дээшлүүлэх институтын захирал, Д.Сүрэнчимэг, ахмад судлаач Б.Бурмаа, Монгол дахь олон улсын Жайка байгууллагын хэрэгжүүлж буй ПРОЦЕСС төслийн мэргэжилтэн Фукио Томохиро, улсын тэргүүний “Ган зам” 20-р сургуулийн захирал, МУ-ын Гавьяат багш, Н.Батбаяр, Сэлэнгэ аймгийн салбар зөвлөлийн төлөөлөгч М.Баасанхүү, Орхоны аймгийн IV цэцэрлэгийн хамт олон мэндчилгээ дэвшүүлж үг хэллээ.



Хичээлийн судалгааны арга зүйг манай оронд сурагчдын суралцахуйг дэмжих багшлах арга зүйг хөгжүүлж, түгээн дэлгэрүүлэх үйлсэд өөрийн үнэтэй хувь нэмрийг оруулсан Монголын болон Японы зарим ахмад багш У.Доёд, Б.Бурмаа, Н.Нэргүй, О.Чулуунцэцэг, Г.Нэргүй, Японы Токио

хотын Минато дүүргийн “Минато хичээлийн судалгааны академи”-ийн удирдах зөвлөлийн гишүүн ахмад багш Фүкүчи Аkitэрү, Тояма Ёширо, Орий Мичио, нарт Монголын Хичээлийн Судалгааны нийгэмлэгийн 5 жилийн ойг тохиолдуулан шинээр бий болгосон ХҮНДЭТ ДЭВТЭРТ нэрийг нь бичин алдаршуулж, гэрчилгээ олгосон нь оролцогчдын сэтгэлийг хөдөлгөсөн арга хэмжээ байлаа.



Хичээлийн судалгааны чиглэлээр анхны доктор Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн Хөтөлбөрийн хорооны дарга Т.Ганбаатар, Дэлхийн Хичээлийн Судалгааны Нийгэмлэгийн хуралд анхны илтгэл хэлэлцүүлсэн Монгол Улсын Их Сургуулийн Шинжлэх Ухааны Сургуулийн Химийн тэнхимийн багш Ч.Нямгэрэл нарт, МХСН-ийн анхны салбар зөвлөлийг байгуулсан Сэлэнгэ аймгийн салбар зөвлөлд “Анхдагч”-ийн батламж гардууллаа.

Ойн ёслол хүндэтгэлийн үйл ажиллагаанд улсын тэргүүний “Ган зам” 20-р сургуулийн багш Д.Амгаланбаатар морин хуурын аялгуу эгшиглүүлж, МУБИС-ийн багшийн сургуулийн оюутнуудтай хамт нийт оролцогчид “Багшаа дуулья” дуугаа дуулсанаар ёслол хүндэтгэлийн арга хэмжээ өндөрлөж, бага хурлын үйл ажиллагаа эхэллээ.





Монголын Хичээлийн Судалгааны Нийгэмлэг (МХСН) үүсэн байгуулагдсаны 5 жилийн ойн арга хэмжээг хааж МХСН-ийн гүйцэтгэх захирал Н.Оюунцэцэг үг хэлж, ойн бүх оролцогчид, МХСН-ийн үүсэг байгуулагчид, удирдах зөвлөлийн гишүүд, нийт гишүүд дэмжигчдэдээ баяр хүргэлээ.

Мөн ойн арга хэмжээг зохион байгуулсан ажлын хэсэг, хандив өгсөн бүх гишүүддээ талархал илэрхийллээ.



Ойн хүндэтгэлийн арга хэмжээний дараа зохион байгуулсан онол практикийн VI бага хуралд хичээлийн судалгааны мэргэжилтэн, их дээд сургуулийн багш судлаачид, орон нутгийн боловсролын газрын мэргэжилтэн, СӨБ, ТХБ болон ЕБС-ийн аман болон ханын илтгэл хэлэлцүүлсэн сургуулийн захирал, менежер, багш нар, хүндэт зочид, сонирхсон оролцогчид, хурлыг зохион байгуулах ажлын хэсгийн ажилтан зэрэг 270 гаруй хүн оролцсон байна.

МОНГОЛЫН ХИЧЭЭЛИЙН СУДАЛГААНЫ НИЙГЭМЛЭГ 2018.12.03

МХСН-ийн 5 жилийн ойн арга хэмжээнд хандив өргөсөн гишүүд, дэмжигчиддээ баярлалаа:

Сар, өдөр	Гишүүд, дэмжигчид	Хандив (төг.)
10.08	Г.Бадамханд, Д.Бүжин, Д.Анхбилэг, Дорнод, Хэрлэн-12	30.000
10.08	Золбоотын Нарангарав	20.000
10.09	Завханы мандал сумын сургуулийн багш нар	140.000
10.12	Завхан сумын сургуулийн багш нар (Ванчиндорж)	105.000
10.12	Я.Нарангэрэл, Завхан аймаг	50.000
10.15	Завханы Баянтэс сумын сургуулийн багш нар	103.000
10.16	Сузуки Саяака, МХСН	500.000
10.16	Иший Тэцүяа, МХСН	500.000
10.16	Г.Норжмаа, МХСН	150.000

10.17	Завхан аймгийн Тосонцэнгэл сумын сургуулийн багш нар	130.000
10.19	Ч.Нямгэрэл, МХСН	100.000
10.19	Г.Юмчмаа, МУИС	100.000
10.22	Химийн судлагдахууны баг (Ц.Отгонбаяр нарын)	130.000
10.24	Д.Одгэрэл, Завхан аймаг	40.000
10.25	З.Урансайхан, химийн судлагдахууны баг	50.000
10.29	Ш.Сайнбилэг, химийн судлагдахууны баг	30.000
10.29	Ц.Намжилдорж, МХСН-ийн зөвлөх, 45- сургуулийн захирал асан	100.000
10.31	Бага боловсролын математикий баг (Чулуунцэцэг ба бусад).	120.000
11.01	Б.Хишигбаяр, МХСН УЗ	200.000
11.02	Сэлэнгэ аймгийн Мандал сумын IV сургуулийн гишүүд	100.000
11.02	А.Дэмбэрэлнямбуу, Шинэ үе сургуулийн сургалтын менежер	100.000
11.04	Мэдээлэл зүйн судлагдахууны баг (Золзаяа, Мөнхтуяа ба бусад)	200.000
11.04	Да.Энхтуяа, МХСН	50.000
11.08	П.Пүрэвдорж, физикийн судлагдахууны багийн гишүүн	50.000
11.13	Н.Батбаяр, МХСН-ийн зөвлөх, "Ган зам" 20-р сургуулийн захирал	500.000
11.13	М.Ганбат, МХСН УЗ (МУИС)	100.000
11.14	Б.Тунгалаг, Өмнөговь аймгийн 6-р сургуулийн багш	50.000
11.14	Мэдээлэл зүйн судлагдахууны баг (нэмсэн)	20.000
11.14	Орхон аймгийн 4 цэцэрлэгийн багш нар	100.000
11.14	Хүн орчин судлагдахууны баг	80.000
11.15	Н.Оюунцэцэг, МХСН УЗ	100.000
11.16	Хөвсгөл аймгийн ДМЦС-ийн багш нар	200.000
11.16	Дорнод аймгийн Хэрлэн-12 сургуулийн багш нар	150.000
11.16	БМДИ-ийн арга зүйч гишүүд	150.000
11.16	М.Ганбат, МХСН, (нэмсэн)	50.000
11.16	Урантогос, Дорнод физикийн багш	50.000
11.16	Одонцацрал, Гёте сургуулийн багш	50.000
11.16	Р.Энхбат, УБ, 1-р сургуулийн багш	50.000
11.16	Л.Сувдаа, Сэлэнгэ аймгийн салбар зөвлөлийн дарга	50.000
11.16	Сэлэнгэ, Хушаат сумын сургуулийн багш нар	50.000
11.17	Т.Ганбаатар, МХСН УЗ (МУБИС)	100.000
11.17	Завхан аймгийн Чандмана-Эрдэнэ сургуулийн багш нар	210.000
11.28	Сэлэнгэ Түшиг сумын багш нар	100.000